

СУРГУУЛИЙН ӨМНӨХ, БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ЦӨМ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг илрүүлэн сайжруулах, ололт амжилт сайн туршлага, технологийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх

ХОЁР. ЗОРИЛТ

- 1. Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх, стандарт хэрэгжилт тогтоох, сургалт зохион байгуулах
- 2. Сургууль, цэцэрлэгийн менежментийн хэрэгжилтийн бодит үр дүнтэй танилцах, зөвлөн туслах
- 3. Амжилт, туршлагын сантай танилцах, бүртгэх, цуглуулах, сурталчлах
- Зөвлөн туслах ажлын үр дүнг нэгтгэн зөвлөмж боловсруулан танилцуулах

ГУРАВ. ХҮРЭХ ҮР ДҮН

- Хүүхэд бүрийн суралцахуйн хөгжлийг дэмжсэн хичээлийн төлөвлөлт боловсруулах, хэрэгжүүлэх арга барилд суралцана.
- Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлаа хамтран шийдвэрлэсэн байна.
- Сургууль, багш нарын сайн туршлага, арга технологийг сурталчилж түгээнэ.

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Нийслэлд: 8 дүүргийн нийт 34 сургууль, 29 цэцэрлэг

ТАВ. ХУГАЦАА

2017 оны 09-р сарын 26 - наас – 2017 оны 12-р сарын 15 –ныг хүртэл

ЗУРГАА : АЖИЛЛАХ БАГ БҮРЭЛДЭХҮҮН:

- Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн
- Дүүргийн Боловсролын хэлтсийн мэргэжилтэн
- Нийслэлийн сургагч багш нар

ДОЛОО. АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилт

- Сургалтын цөм хөтөлбөр хэрэгжилтийн талаар санал солилцох, ярилцах, зөвлөх
- Нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй танилцах
- Багш нарын 2-3 цагийн хичээлд суух, ажиглах, сайн арга, туршлагыг илрүүлэх, дэмжлэг үзүүлэх
- Сонгосон ангиас стандарт хэрэгжилтийн шалгалт авах, үр дүнг тооцох, агуулгын зөвлөмж өгөх
- Сургалтын орчин бүрдүүлсэн байдалд зөвлөх
- Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, ашиглах арга зүйн зөвлөгөө өгөх

2. Сургуулийн менежментийн хэрэгжилт

- Сургалтын төлөвлөгөө, сургуулийн зорилго, зорилт, төлөвлөлт, бүтэц зохион байгуулалт, сургалтын хуваарь, сургуулийн орчинтой танилцах
- Амжилт, туршлагын сантай танилцах, бүртгэх, цуглуулах
- Зөвлөн туслах ажлын үр дүнг нэгтгэн цаашид юуг анхаарч ажиллах талаар зөвлөмж боловсруулан сургууль бүрд өгөх, үр дүнг тайлагнах

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ ДЭЭР АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цаг	Үйл ажиллагааны чиглэл	Арга хэлбэр
8.00-8.20	Сургууль, цэцэрлэгийн удирдлагатай уулзаж ажлын чиглэлээ танилцуулах	Танилцуулга
8.20-9.00	Сургууль, цэцэрлэгийн менежмент, сургуулийн хөтөлбөртэй танилцах, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх/ удирдлага/	Зөвлөгөө
8.20-9.00	Багш нарын нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр, төлөвлөлтөд шинжилгээ хийх / мэргэжилтнүүд/	Шинжилгээ
9.00-13.00	Багш нарын хичээлд суух, ажиглалт хийх	Ажиглалт судалгаа
9.00-13.00	Сонгосон ангиас стандарт хэрэгжилтийн шалгалт авах	Түүвэр судалгаа, анализ
14.00-15.00	Хичээлийн хэлэлцүүлэг, зөвлөгөө өгөх, хичээлийн төлөвлөлтийг хамтран сайжруулах	Хэлэлцүүлэг, зөвлөгөө, багаар ажиллах
15.00-16.00	Мэргэжлийн багш нартай уулзалт, ярилцлага хийх (сургалтын хөтөлбөр, сурах бичиг, суралцахуйн зөвлөмжийн талаар) Санал асуулга хуудас бөглүүлнэ.	Ярилцлага, зөвлөгөө өгөх, санал авах
16.00-16.10	Багш нартай ажилласан тэмдэглэл, хичээлийн ажиглалтын хуудас, шалгалтын дүнг хэлтсийн даргад нэгтгэж өгнө.	Баримт бичгийн шинжилгээ, ярилцлага
16.20-17.00	Нэгдсэн уулзалт хийх / тухайн өдрийн ажлаа дүгнэн сургууль, цэцэрлэгийн хамт олонд танилцуулах, зөвлөгөө өгөх/	Фото, ярилцлага, зөвлөгөө

Багийн ахлагчийн үүрэг:

- Багаа зохион байгуулалт, удирдлагаар ханган ажиллах
- Тухайн сургуульд ажиллах ажлын ерөнхий хүрээний дагуу багийн төлөвлөлтөө тухайн сургуультайгаа хамтран өдөр өдрөөр, цагаар нарийвчлан гаргаж, гишүүддээ ажил үүргийг хуваарилж чанартай гүйцэтгүүлэх
- Ажлын чиглэл бүрээр цуглуулсан мэдээллийг мэргэжилтэн бүрээс авах хавтаст хийж цэгцлэх
- Үйл ажиллагааны тайлан, зөвлөмжийг ажил дууссанаас хойш 2 өдрийндотор хэлтсийн даргад өгөх

Мэргэжилтнүүдийн үүрэг:

- Өгөгдсөн үүрэг даалгаврыг хариуцлагатай, чанартай гүйцэтгэх
- Цаг баримтлан ажиллах
- Стандарт хэрэгжилтийн шалгалтын материалыг боловсруулж, засалт хийж, анализ хийж дүнг нэгтгэн өгөх
- Багш нараас санал асуулга авах
- Багш нараас гарсан санал, хүсэлт, асуулт, зөвлөсөн ажлын агуулга, арга хэлбэр, хийсэн ажлын шинжилгээ, дүгнэлт, санал зэргийг тусгасан тайланг багийн ахлагчид өгөх